

Говьсүмбэр аймаг дахь
Төрийн аудитын газар



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“ТӨРӨӨС ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ, АЖЛЫН БАЙРЫГ
НЭМЭГДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН БОДЛОГЫН
ХЭРЭГЖИЛТ ҮР ДҮН”-Д ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: ГСА-2022/20-6-ШТА-ГА

Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын
газрын дарга, тэргүүлэх аудитор:
Б.Сарантуяа, Утас: 70543156
Цахим хаяг: Sarantuyab@audit.gov.mn

Аудитын менежер: Г.Наранбаяр,
Утас: 70543179
Цахим хаяг: Naranbayarg@audit.gov.mn

Ахлах аудитор: Ц.Батсайхан, Утас: 70543179
Цахим хаяг: Batsaikhants@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт
мэдээллийг дараах хаягаар авна уу.
Цахим хуудас: www.audit.mn

Тайланг бэлтгэсэн:

Говьсүмбэр аймаг дахь
Төрийн аудитын газар

Дарга, тэргүүлэх аудитор
Б.Сарантуяа

Аудитын менежер
Г.Наранбаяр

Ахлах аудитор
Ц.Батсайхан

Аудитын тайлан,
дүгнэлттэй холбоотой
асуудлаар нэмж тодруулах,
асууж лавлах зүйл байвал
70543156, 70543179
дугаарын утсаар харилцана
уу.

ХАЯГ:

Сүмбэр сум 3-р баг,
Нутгийн удирдлагын
ордон, 205 тоот

2022 оны 5 дугаар сар

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГС 3

БҮЛЭГ 1. Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр орон нутгийн онцлогт тохирсон бодлогын баримт бичиг боловсруулаагүй, төрийн байгууллагуудын ажлын уялдаа холбоо, хамтын ажиллагааг сайжруулах шаардлагатай байна 8

1.1 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр урт болон дунд хугацаанд хэрэгжүүлэхээр баталсан бодлогын баримт бичгүүдийн хоорондын уялдаа бүрэн хангагдахгүй байна. 8

1.2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих ажлын байрыг нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг үндэслэлтэй төлөвлөж чадаагүй байна. 10

1.3 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиг үүрэг бүхий төрийн байгууллагуудын ажлын уялдаа холбоо, хамтын ажиллагааг сайжруулах шаардлагатай байна. 13

БҮЛЭГ 2. ХЭДС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн хангалтгүй, ажилгүйдэл буураагүй байна. 18

2.1 Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээнд хамаарах үйл ажиллагааны үр дүнг үнэлж, тооцоогүй байна. 18

2.2 Засгийн газраас хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажилгүйдлийг бууруулах, ажлын байр нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээ үр нөлөөгүй байна 19

2.3 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг хуулийн дагуу бүрэн төвлөрүүлээгүй байна. 20

2.4 Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн дундаж түвшин 72 хувьтай байна. 23

2.5"Ковид-19" цар тахлын үед хөдөлмөр эрхлэлтийн талаар төрөөс авч хэрэгжүүлсэн арга хэмжээ үр дүнтэй байна. 24

Дүгнэлт

Зөвлөмж

Дээд шатны байгууллагад хүргүүлэх санал

Шалгагдагч байгууллагын санал тайлбар

Тайлан баталгаажуулах тушаал

Тайлангийн хавсралтууд

ТОВЧИЛСОН ҮГС

ААНБ	Аж ахуй нэгж байгууллага
АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт
АИТХ	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
АМЧБО	Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох
ГА	Гүйцэтгэлийн аудит
ГСА	Говьсүмбэр аймаг
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ЗДҮАХ	Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр
МБСДС	Мэргэжлийн боловсрол сургалтыг дэмжих сан
МУЗГ	Монгол Улсын Засгийн Газар
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
НДХ	Нийгмийн даатгалын хэлтэс
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СХС	Сум хөгжүүлэх сан
ТАБ	Төрийн аудитын байгууллага
ТББ	Төрийн бус байгууллага
УИХ	Улсын Их Хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХБИ	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн
ХНН	Хувь нийлүүлсэн нийгэмлэг
ХНХЯ	Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХҮГ	Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар
ХХҮЕГ	Хөдөлмөр халамж үйлчилгээний ерөнхий газар
ХШҮДАХ	Хяналт шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын хэлтэс
ХЭДС	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан
ХЭСЗ	Хөдөлмөр эрхлэлтийн салбар зөвлөл
ХЭҮЗ	Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл
ШТА	Шууд тайлагнах ажил

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Аудит хийх
үндэслэл,
бүрэн эрх:

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2021 оны 06 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2022 оны А/12 дугаар тушаалаар батлагдсан аудитын төлөвлөгөөг үндэслэн, Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэлээ.

Аудитын зорилт:

Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүнг тооцож, дүгнэлт, зөвлөмжийг боловсруулж, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэгдлээ.

Аудитын зорилтыг хангахын тулд аудитыг дараах дэд зорилтын хүрээнд гүйцэтгэлээ. Үүнд:

- Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын баримт бичиг, мөн төрийн байгууллагуудын бүтэц, чиг үүргийн уялдаа холбоо хангагдсан эсэх
- Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажилгүйдлийг бууруулах, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүн, хөрөнгийн зарцуулалт үр ашигтай байгаа эсэх

Аудитад ашигласан
шалгуур үзүүлэлт:

Дараах хууль эрх зүйн актын холбогдох заалтуудыг аудитын шалгуур үзүүлэлт болгон ашиглав.

- ✓ Монгол Улсын Үндсэн хуулийн 25.1.7 дахь заалт
- ✓ Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн 3-20 дугаар зүйл
- ✓ Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 3-6, 8-21, 24 дүгээр зүйл
- ✓ Төсвийн тухай хууль
- ✓ Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 4-26 дугаар зүйл
- ✓ Монгол улсын нэгдсэн төсвийн дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөөллийн тухай хууль
- ✓ Бүсчилсэн хөгжлийн удирдлага, зохицуулалтын тухай хууль
- ✓ Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
- ✓ Коронавируст халдвар / Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль
- ✓ Төсвийн тогтвортой байдлын тухай хууль
- ✓ Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- ✓ 2016 оны 19 дүгээр тогтоол “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030
- ✓ 2016 оны 320 тогтоол “Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг талаар баримтлах бодлого”
- ✓ 2016 оны 45 дугаар тогтоол “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр
- ✓ 2020 оны 52 дугаар тогтоол “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг
- ✓ 2001 оны 57 дугаар тогтоол “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр

Аудитын хамарсан хүрээ:

Аудитын арга зүй:

Аудит хийх багийн бүрэлдэхүүн, хугацаа:

Хүндрэл бэрхшээл:

- ✓ 2020 оны 23 дугаар тогтоол “Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр
- ✓ 2021 оны 119 дүгээр тогтоол “Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах нийтлэг журам”
- ✓ 2020 оны 206 дугаар тогтоол “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”
- ✓ 2011 оны 375 дугаар тогтоол “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах хяналт тавих журам”
- ✓ 2016 оны 276 дугаар тогтоол “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох, түүнд батлан даалт гаргах, хүүг нөхөн төлөх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам
- ✓ 2021 оны 42 дугаар тогтоол “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”
- ✓ 2017 оны 89 дүгээр тогтоол “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”
- ✓ 2016 оны 121 дүгээр тогтоол “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө

Аудитад аймгийн ЗДТГ, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих аймгийн салбар зөвлөл, ХХҮГ-ын 2016-2021 оны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлийн үйл ажиллагааг хамруулав. ХЭДС-ийн 2019,2020 оны үйл ажиллагаанд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг аудитад ашиглав.

Аудитыг АДБОУС (INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС-100, АДБОУС-300, АДБОУС-3000-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын MNS 6817-1:2020 “Төрийн аудит. Тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудитын зарчим”, MNS 6817-7:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудит”, MNS 6817-6:2020 “Төрийн аудит.Нийцлийн аудитын зарчим”, MNS 6817-8:2020 “Төрийн аудит. Нийцлийн аудит”-ын стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан ТАБ-аас аудит хийх журам, түүнд нэмэлт өөрчлөлт оруулсан Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2021 оны А/81 дүгээр тушаал, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2021 оны А/69 дугаар тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал”-ыг ашиглан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулна.

Аудитыг дарга, Тэргүүлэх аудитор Б.Сарантуяа хянан удирдаж, үе шатны хяналтыг аудитын менежер Г.Наранбаяр хэрэгжүүлж, ахлах аудитор Ц.Батсайхан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэлээ.

Аудитын талбарын ажлыг 2022 оны 04 дүгээр сарын 12-ны өдрөөс эхлүүлж, тайланг Тэргүүлэх аудиторовын тушаалаар баталгаажуулан шалгагдагч байгууллага болон холбогдох эрх бүхий албан тушаалтанд 2022 оны 05 дугаар сарын 10-ны өдөр хүргүүлээ.

ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, НТГ-ийн тайлантай аудитын хугацаа давхардаж, хүний нөөцийн дутагдал үүссэн нь аудитад хүндрэл учруулж байлаа.

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Говьсүмбэр аймгийн 3 сумын 5,621 өрхөд 18,153 иргэн амьдарч байна. Үүнээс 50.1 хувь нь эмэгтэйчүүд байна. Хөдөлмөрийн насны хүн ам 10,929, үүнээс 6,300 буюу 57.6 хувь нь ажиллагсад байна.

Говьсүмбэр аймгийн ажилгүйдлийн түвшин 2016-2019 онд 14-57 хувь болж буурч байсан боловч 2020-2021 онд Ковид 19 цар тахлын улмаас 2019 оны суурь түвшингөөс 3 хувиар өссөн байна.

ХЭДС-д 2016-2021 онуудад нийт 2,533.8 сая төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 1,768.7 сая төгрөгийг зарцуулан, 2,645 иргэдийг хамруулж, шинээр байнгын 1,717, түр 825 ажлын байр бий болгосон байна.

Зургийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Зураг 1	Орчин үеийн тоног төхөөрөмжтэй уламжлалт эмнэлэг	25
Зураг 2	“Бялуу үйлдвэрлэл” төсөл хэрэгжүүлэгч	25

График товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
График 1	2016-2021 оны ХБИ ажиллуулаагүй төлбөрийн орлогын төлөвлөлт, гүйцэтгэл	13

Хүснэгтийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	ХЭДС-ийн орлогын 2016-2021 оны төлөвлөлт	11
Хүснэгт 2	ХЭДС-ийн батлагдсан төсөв, санхүүжилтийн гүйцэтгэл	13
Хүснэгт 3	2016-2021 онд СХС-гаас олгосон зээлийн судалгаа	14
Хүснэгт 4	Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн салбар зөвлөлийн 2017-2021 оны төлөвлөсөн ажил, гүйцэтгэл	16
Хүснэгт 5	Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээний үнэлгээ	17
Хүснэгт 6	ХЭДС-гаас 2016-2021 онуудад Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээнд зарцуулсан хөрөнгө	19
Хүснэгт 7	ХЭДС-гийн 2016-2021 оны батлагдсан төсөв, олгосон санхүүжилт	21
Хүснэгт 8	ХЭДС-гийн 2016-2021 оны орлогын судалгаа	21
Хүснэгт 9	2016-2021 онуудад ХЭДС-ын зарцуулалт	23
Хүснэгт 10	Аймгийн МСҮТ-ийн 2016-2020 оны суралцагчийн тоо, батлагдсан төсөв, гүйцэтгэлийн судалгаа	25
Хүснэгт 11	2016-2021 оны төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт	26
Хүснэгт 12	Ажлын байрыг дэмжих болон малчдыг дэмжих зээлийн судалгаа	27
Хүснэгт 13	Хөтөлбөрийн төлөвлөгөө, гүйцэтгэл	29
Хүснэгт 14	Цар тахлын улмаас хөдөлмөр эрхлэлтийн салбарт гарсан өөрчлөлтүүд	29
Хүснэгт 15	Цар тахлын үеийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа	30

Хавсралтын товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хавсралт 1	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүй төлбөрийн 2016-2021 оны судалгаа	31

БҮЛЭГ 1

Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр орон нутгийн онцлогт тохирсон бодлогын баримт бичиг боловсруулаагүй, төрийн байгууллагуудын ажлын уялдаа холбоо, хамтын ажиллагааг сайжруулах шаардлагатай байна

1.1 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр урт болон дунд хугацаанд хэрэгжүүлэхээр баталсан бодлогын баримт бичгүүдийн хоорондын уялдаа бүрэн хангагдахгүй байна.

1.1.1 Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр орон нутгийн онцлогт тохирсон бодлого боловсруулж хэрэгжүүлээгүй байна.

Монгол Улсын Засгийн Газрын 2016 оны 320 дугаар тогтоолоор “Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого”-ыг баталсан хэдий ч уг бодлогын хүрээнд орон нутгийн онцлогт тохирсон тусгайлсан бодлого боловсруулж, батлаагүй байна.

Бодлогын нэгдүгээр үе шат нь 2016-2020 онд хэрэгжиж дууссан бөгөөд УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолоор “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийг баталсантай холбогдуулан “Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлогын баримт бичиг”-ийг МУЗГ-ын 2021 оны 10 дугаар сарын 314 дүгээр тогтоолоор хүчингүй болгожээ.

Аймгийн хэмжээнд орон нутгийн онцлогт тохирсон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх чиглэлийн тусгайлсан бодлогын баримт бичгийг боловсруулан батлуулалгүйгээр зөвхөн Засгийн газрын болон аймгийн дунд болон богино хугацааны бодлогын баримт бичгийн хүрээнд зорилтуудыг төлөвлөн хэрэгжүүлж байгаа нь Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлогын баримт бичигтэй уялдахгүй байгаа төдийгүй хэрэгжилтийг үнэлэх боломжгүй нөхцөл байдал үүсгэж байна.

Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх чиглэлээр Говьсүмбэр аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт 7, 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт 6 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 2016-2020 оны биелэлт 72.9%, 2021 оны биелэлт 89.6%-тай үнэлэгдсэн байна.

Монгол Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 3.3-д “Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, нийгмийн хамгааллыг сайжруулах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ”-ний хүрээнд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр 9 арга хэмжээг төлөвлөсөн байна.

Уг хөтөлбөрт нийцүүлэн аймгийн АИТХ-ын хуралдааны 2016 оны 04 дүгээр тогтоолоор Говьсүмбэр аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр болон хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг баталсан байна.

Аймгийн дунд хугацааны бодлогын баримт бичгийн 3 дахь заалт Нийгмийн бодлогын хүрээнд зорилт 3.5 “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, ажилгүйдлийг бууруулна”, зорилт 3.6 “Зорилтот бүлгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, нийгмийн халамжийн бодлогыг хэрэгжүүлэн ядуурлыг бууруулна” гэсэн 2 зорилтын хүрээнд 7 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгажээ.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн “2.Хүний хөгжлийн бодлого:2.5 Хөдөлмөр, нийгмийн хамгаалал хүрээнд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр 5 арга хэмжээг төлөвлөсөн байна.

Уг хөтөлбөрт нийцүүлэн аймгийн АИТХ-ын хуралдааны 2020 оны 04 дүгээр тогтоолоор “Говьсүмбэр аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл”, 05 дугаар тогтоолоор “Говьсүмбэр аймгийн Засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг баталсан байна. Үндсэн чиглэлийн 2-т Хүний хөгжил-Хөдөлмөрийн зах зээл:Зорилт 2.6 “Хөдөлмөрийн зах зээлийн тэнцвэрт байдлыг хангах, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх бодлого барьж ажиллана” гэсэн зорилтын хүрээнд 3 арга хэмжээг төлөвлөсөн

Аймгийн дунд хугацааны бодлогын баримт бичгийн 2 дахь заалт Хүний хөгжлийн бодлогын хүрээнд Хөдөлмөр, нийгмийн хамгаалал Зорилт 2.5-д “Хүн амын хөгжлийг ханган хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, ажилгүйдэл ядуурлыг бууруулна” гэсэн зорилтын хүрээнд 6 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгажээ.

1.1.2 Аймгийн ЗДТГ, ХХҮГ нь 2019 онд Хөдөлмөр нийгмийн хамгааллын судалгааны институт, “Амжилтын эзэд” ХХК-тай хамтран Орон нутгийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн судалгааг анх удаа зохион байгуулж, судалгааны үр дүнг аймаг, орон нутгийн бодлого, хөтөлбөртөө ашиглах боломжийг бий болгожээ. Судалгаагаар ирэх 3 жилийн хандлагыг тооцоолсон байна.

Хөдөлмөрийн зах зээлийн судалгааны тайланг ХНХЯ-ны хөдөлмөр нийгмийн хамгааллын судалгааны институтын мэдээллийн нэгдсэн санд цахим хэлбэрээр байршуулж, тайланг товхимол болгон хэвлүүлж, орон нутгийн ажил олгогч холбогдох төрийн байгууллагуудад хүргүүлж мэдээ мэдээллээр хангасан байна.

“Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт нийлүүлэлтийн судалгаа”-ны үр дүнд хөдөлмөр эрхлэлтийн бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэх, ажилгүйдэл ядуурлыг бууруулах, эрэлттэй болон илүүдэлтэй ажил мэргэжлийг тодорхойлох, хүүхэд залуучуудын мэргэжил сонголтод нөлөөлөх зэрэг чиглэлээр мэдээллийн дэлгэрэнгүй сантай болсон боловч уг судалгааг үйл ажиллагаа, бодлогын хэрэгжилтэд ашиглаагүй байна. Судалгаанд үндэслэн боловсруулсан бодлогын баримт бичиг байхгүй байна. Судалгааны үр дүнгээр өгсөн санал зөвлөмжийг холбогдох байгууллагуудад тодорхой өгөөгүйгээс зөвлөмжийг хэрхэн хэрэгжүүлэх нь тодорхойгүй байна.

Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Нэг өрх-Нэг ажлын байр” арга хэмжээг хэрэгжүүлэхээр 2021 оноос төлөвлөн ажиллаж байна.

Уг арга хэмжээний хүрээнд 2021 онд Сүмбэр сумын 1,2,3 дугаар багийн нийт 816 өрхөөс судалгаа авч ажилласан ба судалгаанд хамрагдсан өрхүүдийн 89.4% нь үндсэн харьяат, 10.6% нь түр оршин суугч байна. Судалгааны дүнд үндэслэн нийгмийн халамжийн дэмжлэг тусалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн хөдөлмөрийн насны ажилгүй иргэнийг ажлын байраар хангах, зохистой хөдөлмөр эрхлэх нөхцөлийг бүрдүүлэх, нийгмийн үйлчилгээг цогцоор нь хүргэх замаар ядуурлын түвшинг бууруулах зорилгоор 138 өрхийг сонгон авч, төрийн байгууллагууд 1-4 өрхийг хариуцан авч, чиглүүлэх арга хэмжээг зохион байгуулан ажиллаж байна.

1.1.3 Бодлогын баримт бичгийг боловсруулахад талуудын оролцоог хангаж ажилласан байна.

Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр орон нутагт хэрэгжүүлэх бодлого, хөтөлбөрийг боловсруулж батлаагүй байна.

Аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг бодлогын баримт бичгийг боловсруулахад төрийн байгууллагууд хамтран төслийг боловсруулан төрийн бус байгууллагууд болох аймгийн ажил олгогч эздийн холбоо, Ахмадын хороо, Өөдрөг зөвлөл ТББ зэрэг байгууллагын оролцоог ханган, хэлэлцүүлж, аймгийн ИТХ-д өргөн барьж батлуулсан байна.

1.2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих ажлын байрыг нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг үндэслэлтэй төлөвлөж чадаагүй байна.

1.2.1 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг үндэслэлтэй тооцоогүй байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт ОНХС-аас 220.0 сая төгрөгөөр төлөвлөж, ХЭДС-аас мөнгөн дүнгүйгээр төлөвлөжээ. Харин 2020-2024 оны ЗДҮАХ-т ХЭДС-аас 27.2 сая, улсын төсвөөс 3,091.3 сая, ОНХС-аас 45.0 сая төгрөгийн эх үүсвэр төлөвлөсөн байна.

Бодлогын баримт бичгүүдэд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх үйл ажиллагааны чиглэлээр тусгагдсан зорилтуудыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг тусгасан хэдий ч хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр хөтөлбөрт суурилсан төсвийг тусгайлан төлөвлөж, батлаагүй байна.

Аймгийн ХХҮГ-аас ХЭДС-гаас хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээний төсвийг төлөвлөхдөө зөвхөн улсын төсвөөс авах эх үүсвэрийг тооцоолж, орон нутгийн төсвөөс шаардагдах төсвийн тооцооллыг гаргаж, аймгийн ИТХ-д санал хүргүүлдэггүй байна. Иймээс аймгийн ХЭДС-д 2016-2021 онуудад орон нутгийн төсвөөс зардлын эх үүсвэр төлөвлөж, батлагдаагүй байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэхэд шаардлагатай санхүүжилтийн гол эх үүсвэр нь улсын төсвөөс хуваарилж буй ХЭДС-ийн орлого байна

ХЭДС-ийн орлого төлөвлөлтийн талаар:

Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн тогтоол, ХНХЯ-ны бодлого, ХХҮЕГ-ын чиглэлийг удирдлага болгон олон жилийн гүйцэтгэлийн дунджаар эх үүсвэрээ тодорхойлдог байна.

Аймгийн ХХҮГ нь 2016-2021 онд ХЭДС-ийн орлогыг нийт 2,710.2 сая төгрөгөөр төлөвлөж, төсвийн төслийг хүргүүлсэн байна.

ХЭДС-ийн орлогын 2016-2021 оны төлөвлөлтийг харуулбал:

Хүснэгт №1				/сая төгрөг/
Он	Төсвийн төсөл	Батлагдсан төсөв	зөрүү	
2016	606.6	270.2	336.4	
2017	423.8	265.5	158.3	
2018	290.0	837.9	- 547.9	
2019	361.1	525.3	- 164.2	
2020	557.2	308.4	248.8	
2021	471.5	326.6	144.9	
Дүн	2,710.2	2,533.9	176.3	

Эх сурвалж: ХЭДС-ийн 2016-2021 оны төсвийн төсөл

ХЭДС-ийн орлогыг 2016-2021 онуудад 2,710.2 сая төгрөгөөр төлөвлөн төсвийн төслийг хүргүүлсэн бол 2,533.9 сая төгрөгөөр батлагдаж, төсвийн төслийн дүнгээс нийтдээ 176.3 сая төгрөгөөр буурчээ. Төсвийн төслийг хүргүүлсэн саналаас 2018, 2019 онд нэмэгдүүлсэн баталсан бол бусад онуудад бууруулан баталжээ. Энэ нь дээд байгууллагад хүргүүлсэн төсвийн төслийн

санал буюу төлөвлөлт жил бүр Засгийн Газрын бодлогоос хамаарч өөрчлөлт байнга хийгдэж, төлөвлөснөөс нэлээд өөрчлөгдөж ирдэг байна.

Тайлант хугацааны дундуур ХХҮЕГ-ын Санхүү, төлөвлөлтийн газарт нэмэх, хасах санал хүргүүлэн өөрчлөлт оруулж, зохицуулалт хийж ирсэн байна.

Санхүүжилтийг өмнөх оны төсвийн гүйцэтгэлд үндэслэн төлөвлөж байгаа нь хөтөлбөрүүдийг зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн судалгаанд суурилан бодитой тооцож, төсөвлөж чадахгүй байгааг харуулж байна.

Мөн ХЭДС-ийн орлогыг төлөвлөхдөө ХБИ ажиллуулаагүй төлбөрийн орлогыг судалгаанд суурилан бодитоор тооцоолоогүй байна.

2016-2021 оны ХБИ ажиллуулаагүй төлбөрийн орлогын төлөвлөлт, гүйцэтгэлийг графикаар харуулбал: /сая төгрөгөөр/

График №1



2016-2021 онд 81 ААНБ-аас 758.3 сая төгрөгийн ХБИ ажиллуулаагүй төлбөрийн орлогыг авах боломжтой байсан бол 13.3 сая төгрөгийн орлого бүрдүүлэхээр батлагдаж, гүйцэтгэлээр 35 байгууллагаас 85.3 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлэн, 46 байгууллагаас 673.0 сая төгрөгийн орлого олох боломжтой мэт харагдаж байгаа боловч ХБИ орлогыг төвлөрүүлэхэд бодит нөхцөл байдал дээр дараах хүндрэл бэрхшээлүүд тулгарч байна. /Дэлгэрэнгүй судалгааг хавсралт 1-ээр дэлгэрэнгүй харуулав/ Үүнд:

1. Хуулийн хэрэгжилтийг хангуулахад хууль эрх зүйн зохицуулалт нь тодорхойгүй
2. ААНБ-ууд хуульд заасан үүргээ биелүүлэхдээ хойрго ханддаг, тэдэнд ноогдуулах арга хэмжээг авах эрх мэдэл ХХҮГ-т байдаггүй
3. ХХҮГ нь Нийгмийн даатгалын байгууллагаас гаргуулан авсан цалингийн мэдээнд тулгуурлан тооцоог гаргаж нэхэмжилдэг, албан тоот хүргүүлэхээс өөр арга хэмжээ авч чаддаггүй, хууль эрх зүйн орчин нь байхгүй
4. Орлогыг бүрдүүлэгч төмөр замын ХНН-ийн харьяа байгууллагууд, цэрэг цагдаа хүчний байгууллагууд нь мэргэжлийн онцлог, тусгай байгууллага зэргээс шалтгаалан ХБИ иргэн ажиллуулах боломжгүй гэсэн шалтгаанаар төлдөггүй, мөн төлбөрийн чадваргүй, тухайн жилийн төсөвт нь төлбөр нь батлагддаггүй төсвийн байгууллагууд байдаг
5. Орлогыг бүрдүүлэх талаар аймгийн МХГ зэрэг мэргэжлийн байгууллагад уламжилдаг боловч тодорхой үр дүнд хүрдэггүй, хамтын ажиллагаа муу

Дээрх нөхцөл байдлаас харахад хууль эрх зүйн орчныг сайжруулахгүй бол ХХҮГ-ын үйл ажиллагаанаас үл хамаарч ХБИ ажиллуулаагүйн төлбөрийн орлогыг бодит тооцоо судалгаанд үндэслэн төлөвлөх, бүрдүүлэх боломжгүй байна.

Иймд ХБИ ажиллуулаагүйн төлбөрийн орлогыг бүрдүүлэх хууль эрх зүйн орчныг сайжруулах саналыг ҮАГ-т уламжлахаар шийдвэрлэв.

1.2.2 Сум хөгжүүлэх сангийн орлогыг бодлогын баримт бичигт эх үүсвэрээр тооцож төлөвлөөгүй байна

Орон нутгийн дунд болон богино хугацааны бодлогын баримт бичигт Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлогыг хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэрийг улсын төсөв, байгууллагын төсөв, ХЭДС, ОНХС-ийн орлогоос бүрдүүлэхээр төлөвлөж ирсэн байна.

1. ХЭДС-ийн орлогын эх үүсвэрийн талаар:

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1-т заасны дагуу 9 нэр, төрлийн орлогын эх үүсвэр бүрдэхээр хуульчлагдсан байна. Аймгийн хувьд ХЭДС-ийн орлогыг улсын төсвөөс хуваарилсан хөрөнгө, зээлийн эргэн төлөлт, ХБИ- ажиллуулаагүй орлогоос бүрдүүлэхээр төлөвлөдөг байна.

2016-2021 онд улсын төсвөөс 2,533.9 сая төгрөгийг баталж, гүйцэтгэлээр 2,040.6 сая төгрөгийн санхүүжилт олгож, 493.3 сая төгрөгийн санхүүжилтийг дутуу олгосон байна.

ХЭДС-ийн батлагдсан төсөв, санхүүжилтийн гүйцэтгэл

Хүснэгт № 2

Он	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	/сая төгрөг/ Зөрүү
2016	270.2	270.2	0
2017	265.5	193.8	71.7
2018	837.9	453.5	384.4
2019	525.3	506.2	19.1
2020	308.4	310.0	-1.6
2021	326.6	306.8	19.8
Нийт	2,533.9	2,040.6	493.3

Эх сурвалж: ХХҮГ-ын 2016-2021 оны төсвийн гүйцэтгэлийн мэдээ

Хүснэгтээс харахад: 2018, 2019 онуудад хамгийн өндөр төсөв батлагдсан бол 2020, 2021 онуудад улсын төсвөөс авдаг санхүүжилт өмнөх оноос буурсан нь ковид-19 цар тахалтай холбоотойгоор төсөл, хөтөлбөрүүд хэрэгжихгүй байх нөхцөл бүрдсэнтэй холбоотой байна.

2. Сум хөгжүүлэх сангийн орлогын талаар

Сум хөгжүүлэх сан нь сумдад жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх зорилгоор улсын төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр байгуулагдсан юм.

Орон нутгийн хэмжээнд Сум хөгжүүлэх сан нь 2011 оноос эхлэн байгуулагдсан.

2016-2021 онуудад Сум хөгжүүлэх сангаас нийтдээ 58 иргэнд 605.7 сая төгрөгийн зээлийг олгож, 67 ажлын байрыг бий болгосон байна.

2016-2021 онд СХС-гаас олгосон зээлийн судалгаа

Хүснэгт №3

/сая төгрөг/

Сумдын нэр, он	2016	2017	2018	2019	2020	2021	Зээлдэгчийн тоо	Зээлийн хүрээнд бий болсон ажлын байрны тоо
Сүмбэр сум	44.7	-	131.0	153.0	0	0	25	33
Шивээговь сум	34.0	0	0	0	89.0	0	21	20
Баянтал сум	0	0	0	79.0	0	75.0	12	14
Нийт дүн	78.7	-	131.0	232.0	89.0	75.0	58	67

Эх сурвалж: СХС-аас гаргуулан авсан 2016-2021 оны судалгаа

Сум хөгжүүлэх сангаас олгосон зээлийн хүрээнд хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж ажлын байрыг болгосон байтал СХС-ийн зээлийн эх үүсвэрийг орон нутгийн дунд болон богино хугацааны бодлогын баримт бичигт эх үүсвэрээр тооцож төлөвлөөгүй байна.

2021 оны жилийн эцсийн байдлаар сангуудын үлдэгдэл 484.5 сая төгрөгийн эх үүсвэртэй байгаа нь орон нутагт хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэхэд шаардагдах хөрөнгийн нөөц байгааг харуулж байна.

Үүнээс харахад Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийн эх үүсвэрийг оновчтой тодорхойлж, тусгаж чадаагүй байна.

1.2.3 Орон нутгаас хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх төсөл хөтөлбөрт шаардлагатай санхүүжилтийг ХЭДС-д хуваарилдаггүй байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жил бүр баталсан төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр санхүүжилтийг хуваарилдаг байна.

ХЭДС-аас зарцуулах санхүүжилтийг төсөл, хөтөлбөр бүрээр ХЭҮЗ-өөс баталсан тогтоол, аймаг дахь ХЭСЗ-ийн шийдвэрээр батлагдсан төлөвлөгөөний дагуу зарцуулдаг байна. 2016-2021 онуудад хөдөлмөр эрхлэлтийг дэмжих 9 хөтөлбөр, арга хэмжээнд нийт 2,533.9 сая төгрөгийг баталж, улсын төсвөөс санхүүжүүлсэн байна.

Санхүүжилтээр хуваарилсан хөрөнгийн 959.1 сая төгрөг буюу 63.9%-ийг санхүүгийн дэмжлэгт олгосон байна. Санхүүгийн дэмжлэг олгож буй хөтөлбөрүүдээс ажлын байрыг дэмжих хөтөлбөр, Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт түлхүү санхүүжилт хуваарилсан байна.

Харин орон нутгаас хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх төсөл хөтөлбөрт шаардлагатай санхүүжилтийг ХЭДС-д хуваарилаагүй байна

1.3 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиг үүрэг бүхий төрийн байгууллагуудын ажлын уялдаа холбоо, хамтын ажиллагааг сайжруулах шаардлагатай байна.

1.3.1 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр төрийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагааны төлөвлөгөөний уялдаа хангалтгүй байна.

Орон нутгийн хэмжээнд дунд болон богино хугацааны баримт бичгүүдэд тусгагдсан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлогыг арга зүйгээр хангах чиг үүргийг аймгийн АЗДТГ-ын

Нийгмийн бодлогын хэлтэс, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр үндсэн үйл ажиллагаа явуулах байгууллага нь Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар байна.

Аймгийн ХХҮГ нь хөдөлмөр эрхлэлтийн бодлогыг хэрэгжүүлэх, үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүрэг бүхий төрийн бусад байгууллагууд болох аймгийн МХГ, НДХ, Политехник коллеж, Ажил олгогч эздийн холбоо зэрэг бусад мэргэжлийн холбоодтой хамтран ажиллаж байна.

2021 оноос аймгийн Засаг дарга, сумдын Засаг дарга нартай байгуулах гэрээнд сумдад шинээр ажлын байр бий болгох зорилт арга хэмжээг тусгаж, жилийн эцсийн гэрээнд биелэлтийг дүгнэж ажилласан байна.

Аймгийн ХХҮГ нь 2019-2020 онд ХЭД чиглэлээр хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээ, батлагдсан төсвийн талаарх мэдээллийг сумдын ЗДТГ-т оны эхэнд албан тоотоор хүргүүлж, сумын удирдлагууд болон багийн дарга нарт танхимын сургалтаар мэдээллийг өгч, иргэдэд мэдээллийг хүргэхэд хамтран ажиллажээ.

Аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтэс нь бусад төрийн байгууллагад бодлого, арга зүйгээр хангаж хамтран ажиллах байдал хангалтгүй, бусад байгууллагуудаас ирсэн тайлан, мэдээг нэгтгэж холбогдох байгууллагуудад хүргүүлдгээс өөр хийсэн дорвитой ажил харагдахгүй байна, жил бүрийн ажлын төлөвлөгөө, тайланг бүрэн архивлаагүй байна.

Аймгийн ХХҮГ нь аймгийн Политехник коллеж, НДХ-тэй хамтран ажиллаж байгаа байдал хангалтгүй байна. Тухайлбал: ХЭДС-аас хэрэгжүүлсэн хөтөлбөрийн үр дүнгээр ажлын байрыг бий болгож байгаа иргэнд НДШ төлөх шаардлагыг тавьдаг ч байгууллага хоорондын мэдээллийн урсгал сайн биш, политехник коллежийн элсэлт, төгсөлтийн мэдээг боловсруулж, хөдөлмөрийн зах зээлд хамтарч ажиллаж байгаа байдал нь хангалтгүй байна.

Иймд бодлогын хэрэгжилтийг хангахад ажлын уялдаа холбоогоо сайжруулж, хамтран ажиллах зөвлөмжийг холбогдох байгууллагуудад хүргүүлэхээр шийдвэрлэв.

1.3.2 Төсөв, санхүүгийн эх үүсвэр дутагдалтайгаас бүс нутгийн онцлогт тохирсон зохицуулалт, хяналтын арга хэмжээ авч ажиллах боломжгүй байна.

Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн тогтоолоор 21 аймаг, 9 дүүрэгт зохион байгуулах хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүд батлагддаг ба Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газраас нэгдсэн зохион байгуулалтаар хийх арга аргачлал, зохицуулалт, удирдамж, чиглэлийг өгч ажилладаг тул одоогоор орон нутгийн онцлогт тохирсон зохицуулалт байхгүй байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө аймгийн нийт салбарын тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд хүрэлцдэггүй. 2020 онд ХЭАЗ-өөс “Орон нутгийн онцлог хэрэгцээнд нийцүүлсэн зорилтот төсөл”-ийг хэрэгжүүлэхээр 200.0 сая төгрөгийн нэмэлт санхүүжилтийг шийдвэрлүүлэх саналыг ХХҮЕГ-т хүргүүлсэн боловч төсөв батлагдаж ирээгүй байна.

Аймгийн салбар зөвлөл нь ХЭҮЗ-өөс жил бүр хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр хэрэгжүүлдэг “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүд-ийн хүрээнд батлагдсан ХЭДС-ийн төсвийг хүрэлцээтэй гэж үзээд орон нутгийн төсвөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зориулалтаар тусгайлсан хөтөлбөр, хөрөнгө батлаагүй байна. ХЭДС-ийн батлагдсан төсвийн гүйцэтгэл дундаж нь 80-85%-тай зарцуулагдаж байна.

1.3.3 Хөдөлмөр эрхлэлтийн салбар зөвлөл нь дүрэмд заасан чиг үүргийн хүрээнд томоохон бодлогын түвшний ажил төлөвлөөгүй, зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх шаардлагатай байна

Аймгийн Хөдөлмөр эрхлэлтийн салбар зөвлөл нь Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2017 оны 02 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Аймаг, нийслэл, дүүргийн зөвлөлийн дүрэм”-д заасан чиг үүргийн дагуу үйл ажиллагаагаа явуулж байна. Дүрэмд зааснаар салбар зөвлөл нь 8 эрх, 9 үүргийг хэрэгжүүлэхээр байна.

Аймгийн салбар зөвлөлийг дүрэмд заасан төлөөллийг оролцуулан 10 хүний бүрэлдэхүүнтэйгээр аймгийн Засаг даргын 2017.04.13-ны өдрийн А/107, 2019.10.16-ны өдрийн А/347, 2021.04.20-ны өдрийн А/116 дугаар захирамжаар тус тус байгуулсан байна. Зөвлөлийг байгуулсан шийдвэр 3 удаа гарсан нь анх байгуулснаас хойш гишүүд болон зөвлөлийн дарга өөрчлөгдсөнтэй холбоотой байна.

Зөвлөл нь жилдээ хамгийн багадаа 1, ихдээ 3 удаа хуралдаж, ХЭДС-ийн жилийн ажлын төлөвлөгөөг батлах, жилийн зарцуулалтын тайланг хянах, дотоод хяналт шалгалт хийх, тайланг хэлэлцэх зэрэг ажлуудыг хэлэлцэн ажилласан байна. Зөвлөлийн дүрэмд заасан бусад холбогдох заалтуудын хүрээнд тодорхой ажил зохион байгуулаагүй байна.

Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн салбар зөвлөлийн 2017-2021 оны төлөвлөсөн ажил, гүйцэтгэл

Хүснэгт №4

Он	Төлөвлөсөн ажлын тоо	Хэрэгжүүлсэн ажлын тоо	Биелэлт хувиар	Төлөвлөгөөг баталсан эсэх	Гишүүдэд олгосон урамшуулал		Хуралдсан тоо	Салбар зөвлөлөөс гаргасан тогтоолын тоо
					тоо	Дүн /сая.төг/		
2017	10	7	70	Тийм	11	3.8	3	1
2018	8	8	100	Тийм	11	2.6	2	3
2019	15	14.5	96.7	Тийм	11	2.0	2	2
2020	12	10.5	87.5	Тийм	12	1.6	1	1
2021	10	0	0	Үгүй	11	2.2	1	1
Дүн						12.2	9	8

Эх сурвалж: ХЭАЗС-ийн 2017-2021 оны тайлан

2017-2020 онд ажлын төлөвлөгөөг салбар зөвлөлийн даргаар батлуулсан бол 2021 онд ажлын төлөвлөгөөг батлуулаагүй байна.

Төлөвлөгөөний биелэлт 2017 онд 70%, 2018 онд 100%, 2019 онд 96.7%, 2020 онд 87.5%-тай байсан бол 2021 онд төлөвлөгөөний биелэлтийг гаргаагүй тул үнэлэх боломжгүй байна.

Салбар зөвлөлийн үйл ажиллагаанд гишүүдийн үүрэг оролцоо харилцан адилгүй байдал нь хуралдааны тэмдэглэлээс харагдаж байгаа хэдий ч 2017-2021 онд нийт 12.1 сая төгрөгийн урамшууллыг бүх гишүүнд олгосон нь гүйцэтгэсэн ажлын үр дүнтэй уялдаагүй байна. Иймд салбар зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, зөвлөлийн гишүүдийг чадавхижуулах, үүрэг оролцоог нэмэгдүүлэх талаар зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

Салбар зөвлөл нь 2017-2021 онд нийтдээ 9 удаа хуралдаж, 8 тогтоол гаргасан боловч тогтоолын биелэлтийг гаргаж хурлаар хэлэлцээгүй байна.

Зөвлөлийн бүрэлдэхүүнд томилогдсон гишүүд бүгд үндсэн ажил, үүрэгтэй байдаг тул зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулахад хүндрэлтэй байна. Зөвлөлийн дүрэмд зөвлөлийн удирдлага зохион байгуулалтыг тодорхой зааж, зөвлөлийн нарийн бичгийн даргаар ХХҮГ-ын хөдөлмөр, эрхлэлтийн хэлтсийн дарга байхаар заасан нь зөвлөлийн үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэхэд тохиромжтой бус байна.

Зөвлөл нь эрх, үүргийн хүрээнд орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийн бодлого үйл ажиллагааг удирдан зохицуулах, хяналт тавих тул АЗДТГ-ын нийгмийн бодлогын асуудал хариуцсан мэргэжилтэн нарийн бичгийн даргыг хийх нь оновчтой, бодлогын чиг үүрэг үр дүнтэй хэрэгжинэ гэж үзэж байна.

Иймд зөвлөлийн дүрэмд өөрчлөлт оруулах саналыг ҮАГ-т уламжлахаар шийдвэрлэв.

1.3.4 Бодлогын хэрэгжилтэд хөндлөнгийн байгууллагаар хяналт шинжилгээ, үнэлгээ хийлгээгүй байна.

Орон нутгийн түвшинд дунд /ЗДҮАХ/ болон богино /ЭЗНХҮЧ/ хугацааны бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд аймгийн ЗДТГ-ын ХШҮДАХ-ээс хяналт шинжилгээ үнэлгээг журмын дагуу жил бүр хийж ирсэн байна.

Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээний үнэлгээ

Хүснэгт №5

№	Бодлогын баримт бичгийн нэр	Зорилт, арга хэмжээ	Тайлант он /хувиар/				
			2017	2018	2019	2020	2021
1	АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2016-2020 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, ажилгүйдлийг бууруулна	64.3	68.6	81.4	77.1	
2	АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2020-2024 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР	Хүн амын хөгжлийг ханган хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, ажилгүйдэл ядуурлыг бууруулна					89.6
3	АЙМГИЙГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ 5 ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ	Хөдөлмөрийн зах зээлийн тэнцвэрт байдлыг хангах, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх бодлого барьж ажиллана					83.3
4	ГОВЬСҮМБЭР АЙМГИЙГ ХӨГЖҮҮЛЭХ 2021 ОНЫ ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	Хүн амын хөгжлийг ханган хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, ажилгүйдэл ядуурлыг бууруулна					89.6

Харин Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 320 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого”-ын хэрэгжилтэд орон нутгийн түвшинд хяналт шинжилгээ үнэлгээ хийгдээгүй байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2-т “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны үр дүнд *хөндлөнгийн байгууллагаар жил бүр* хяналт, шинжилгээ, үнэлгээ хийлгэнэ”, “Засгийн газрын 2011 оны 375 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх зарцуулах, хяналт тавих журам”-ын 5 дугаар зүйлийн 5.4-д “Сангийн үйл ажиллагаанд мэргэшсэн байгууллагаар хөндлөнгийн үнэлгээ хийлгэж, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлд жил бүр

танилцуулна” гэж заасан боловч мэргэжлийн байгууллагаар хяналт шинжилгээ, үнэлгээ хийлгээгүй байна.

ХЭДС-д МХЕГ-ын даргын 2019 оны 01/221 тоот “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт” удирдамжийн дагуу аймгийн МХГ-аас “Ажлын байрыг дэмжих хөтөлбөр”, “Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-ийн хэрэгжилт, гүйцэтгэл, үр дүнд хяналт шалгалтыг хийсэн байна. Уг хяналт шалгалтаар санхүүгийн дэмжлэгт хамрагдсан боловч төслийн хэрэгжилт хангалтгүй, санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлтийг гэрээний хуваарийн дагуу төлөөгүй нийт 8 иргэн, 1 аж ахуй нэгж байгууллагад нийт 113.8 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоосон байна.

Хяналт шалгалтын мөрөөр актыг барагдуулах арга хэмжээг авч, 3 иргэн, 1 аж ахуй нэгж байгууллагын нийт 90.1 сая төгрөгийн актыг барагдуулж, хэрэгжилт 80.0%-тай байна.

Аймаг дахь Төрийн аудитын газраас “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгосон хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилт”-д 2019,2020 оныг хамруулан 2021 онд гүйцэтгэлийн аудит хийж, 90.6 сая төгрөгийн зөрчил илрүүлж, зөрчлийг арилгуулах, давтан гаргахгүй байх 13.0 сая төгрөгийн 2 албан шаардлага, үйл ажиллагааны үр дүнг сайжруулах чиглэлээр 8 зөвлөмж өгч ажилласан. Албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт 50%-тай байна.

БҮЛЭГ 2

ХЭДС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн хангалтгүй, ажилгүйдэл буураагүй байна.

2.1 Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээнд хамаарах үйл ажиллагааны үр дүнг үнэлж, тооцоогүй байна.

2.1.1 Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах, ажилд зуучлах арга хэмжээний үр дүнг үнэлээгүй байна.

Аймгийн ХХҮГ нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих нийтлэг үйлчилгээнд 2016-2021 онуудад 32.0 сая төгрөгийг зарцуулж, нийт 15,617 иргэнийг хамруулсан байна.

ХЭДС-гаас 2016-2021 онуудад Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээнд зарцуулсан хөрөнгө
Хүснэгт №6 /сая төгрөг/

Нийтлэг үйлчилгээний зардал		2016 он	2017 он	2018 он	2019 он	2020 он	2021 он	Нийт дүн
Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээ	Мөнгөн дүн	3.6	1.1	2.7	4.3	0.7	3.7	16.2
	Хүний тоо	300	470	645	1,030	245	805	3,495
Ажилд зуучлах үйлчилгээ	Мөнгөн дүн	0.0	0.6	4.6	7.0	2.1	1.5	15.8
	Хүний тоо	70	297	249	492	231	378	1,717

Эх сурвалж: ХЭДС-ийн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Хүснэгтээс харахад: Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээнд 2016-2021 онд 3,495 иргэнийг хамруулж, 16.2 сая төгрөгийг зарцуулсан, ажилд зуучлах үйлчилгээнд 2016-2021 онд 1,717 иргэнийг хамруулж, 15.8 сая төгрөгийг зарцуулсан байна.

2016-2021 онд 2,645 иргэнийг ажилд зуучилж, 1,329 иргэнийг шинээр ажлын байртай болгосон нь ажилд зуучлагдсан иргэдийн 50 хувь ажил хөдөлмөр эрхэлсэн байна.

Мөн жил бүр хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээнд хөрөнгө зарцуулж байгаа боловч хэрэгжилт, үр дүнг тооцоогүй байна.

Иймд Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтэд үндэслэн мэргэжилтэй ажилтныг бэлтгэж, ажил олгогч ажилтан хоёрын эрэлтэд нийцсэн арга хэмжээг зохион зохион байгуулж, үр дүнг тооцож ажиллах зөвлөмж өгөв.

2.1.2 Нэгдсэн бүртгэл, мэдээллийн системийг сайжруулах шаардлагатай байна.

Аймгийн ХХҮГ нь 2013 оноос эхлэн нэвтрүүлсэн, ажил олгогч, хайгч, ажлын байрны захиалга, ажилд зуучлагдсан иргэд, шинэ ажлын байр, ажил мэргэжлийн чиг баримжаа авсан иргэдийн мэдээ тайланг гаргах хөдөлмөрийн зах зээлийн нэгдсэн бүртгэл, мэдээллийн www.lmis.gov.mn программыг ашиглаж эхэлсэн боловч тус программд шинэчлэл хийгдээгүй өдийг хүрсэн, ХЭДС-гаас санхүүгийн дэмжлэг авсан иргэдийг байнгын ажлын байртай болсноор бүртгэдэг, аудитын явцад газар дээр нь очиж танилцахад гацалт ихтэй, мэдээлэл боловсруулалт удаан, иргэдийн мэдээлэл 3 сар болоод идэвхгүй төлөвт шилждэг, мэдээ мэдээлэл үнэн зөв гардаггүй, гараас оруулах мэдээлэл ихтэй байдал ажиглагдсан, мөн хөдөлмөр эрхлэлтийг аймаг, сумаар нь гаргадаггүй, ажил хайгч иргэд ажилтай болсон талаар НДХ-тэй мэдээлэл солилцдоггүй сул талтай зэрэг мэдээлэл технологийн хоцрогдолд орсон тул тус программыг сайжруулах шаардлагатай байна

2.1.3 Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээнд зарцуулсан хөрөнгийн үр ашгийг тооцох боломжгүй байна.

2020 онд ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх зардалд 0.7 сая төгрөгийг зарцуулж, 245 иргэнд ганцаарчилсан зөвлөгөө өгч, ажилд зуучлах зардалд 2.1 сая төгрөгийг зарцуулж, 463 иргэнийг байнгын болон түр ажлын байраар хангасан байна.

2021 онд ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх зардалд 3.7 сая төгрөгийг зарцуулж, 805 иргэнийг хамруулсан байна. Тус онд ажил зуучлах үйлчилгээнд ажил олгогч ААНБ-аас 435 сул чөлөөтэй ажлын байрны захиалга хүлээн авч, иргэнд ажил санал болгож, 450 иргэнийг байнгын болон түр ажлын байраар хангаж, ажилд зуучлах үйлчилгээнд 1.5 сая төгрөг зарцуулсан байна.

2.2 Засгийн газраас хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажилгүйдлийг бууруулах, ажлын байр нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээ үр нөлөөгүй байна

2.2.1 Ковид цар тахлын улмаас олон улсын байгууллагуудын санхүүжилттэй төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлж чадаагүй байна.

Аймгийн ХЭДС-д Дэлхийн банкнаас хөдөлмөрийн зах зээлийн туршилтын хөтөлбөрийн хүрээнд арилжааны банкнаас жижиг зээл авсан иргэдэд зориулан сургалт зохион байгуулахад 2020 онд 5.7 сая, 2021 онд 6.0 сая, нийт 11.7 сая төгрөгийн санхүүжилт олгосон боловч Ковид-19 цар тахлын улмаас сургалтыг зохион байгуулаагүйгээс төсөв хөрөнгө буцаан татагдсан байна.

2.2.2 Аймгийн ХЭДС нь 2016-2021 онд баталсан төсвөөс нийт 493.3 сая төгрөг буюу 19.5 хувийн санхүүжилтийг дутуу авсан байна.

ХЭДС-гийн 2016-2021 оны батлагдсан төсөв, олгосон санхүүжилт

Хүснэгт 7

/сая төгрөг/

Огноо	Батлагдсан төсөв	Олгосон санхүүжилт	Зөрүү	Хувиар
2021	326.6	306.8	19.8	6.1
2020	308.4	310.0	-1.6	-0.5
2019	525.3	506.2	19.0	3.6
2018	837.9	453.5	384.4	45.9
2017	265.5	193.8	71.7	27.0
2016	270.2	270.2	0.0	0.0
Нийт дүн	2,533.9	2,040.6	493.3	19.5

Эх сурвалж: ХЭДС-ийн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Хүснэгтээс харахад: 2020 онд батлагдсан төсвөөс 1.6 сая төгрөг буюу 0.5 хувиар илүү санхүүжилт авч, бусад онуудад 19.0-384.4 сая төгрөгөөр буюу 3.6-45.9 хувиар санхүүжилтийг дутуу авсан байна. Харин 2018 онд арилжааны банкаар олгодог жижиг зээлийн 300.0 сая төгрөгийг сангийн төсөвт оруулж баталснаас батлагдсан төсөв бусад онуудаас өндөр харагдаж байна.

Энэ нь Сангийн төсвийг орон нутгийн онцлогт тохируулан бодит тооцоо судалгаанд үндэслэн төлөвлөж баталдаггүй, оны эцэст зардлын гүйцэтгэлд үндэслэн төсөвт тодотгол хийж, батлагдсан төсвийг бууруулдаг нь харагдаж байна.

2.2.3 Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр нь батлагдаагүй байна.

Засгийн газрын 2016 оны 320 дугаар тогтоолоор баталсан Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлогын 4 дүгээр зүйлийн 4.1.6-т “хөгжлийн бэрхшээлтэй иргэд, эмэгтэйчүүдийн хөдөлмөрийн зах зээл дэх тэгш оролцоог хангах, зохистой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх чиглэлээр төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх” гэж тусгасан боловч улс, орон нутгийн түвшинд тусгайлсан хөтөлбөр нь батлагдаагүйгээс 2016-2021 онд энэ талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ байхгүй байна.

2.3 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг хуулийн дагуу бүрэн төвлөрүүлээгүй байна.

2.3.1 ХЭДС-ийн орлогыг хуульд заасны дагуу бүрэн төвлөрүүлээгүй байна.

ХЭДС-гийн орлого нь хуульд заасан дагуу нийт 9 нэр төрлийн орлогоос бүрдэх боловч аймгийн ХЭДС-д 2016-2021 онд 5 нэр төрлийн орлогоор бүрдүүлсэн байна. Үүнд:

1. Улсын төсвөөс хуваарилсан хөрөнгө
2. Гадаад улс, олон улсын байгууллага, Монгол Улсын болон гадаад улсын аж ахуйн нэгж, байгууллага, төрийн бус байгууллага, иргэдээс Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд оруулсан хандив, тусламж
3. Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулаагүй аж ахуйн нэгж, байгууллагаас төлөх төлбөр
4. Жижиг зээл, санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөгдсөн хөрөнгө
5. Бусад эх үүсвэр

Аймгийн ХЭДС-ийн орлогын эх үүсвэрт 2016-2021 онд нийт 2,552.8 сая төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр 2,797.5 сая төгрөг төвлөрүүлсэн байна.

ХЭДС-гийн 2016-2021 оны орлогын судалгаа

Хүснэгт 8		/сая төгрөг/					
Д/д	Орлогын нэр	2016	2017	2018	2019	2020	2021
1	Улсын төсвөөс хуваарилсан хөрөнгө	270.2	193.8	453.5	506.2	310.0	306.8
2	ХБИ-ийг ажиллуулаагүй ААНБ-аас төлсөн төлбөр	8.4	11.3	1.1	46.1	17.4	1.1
3	Санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлт	63.0	44.6	59.2	160.8	145.8	186.5
4	Гадаад улс ОУБ-ын зээл тусламж				0.0	5.7	6.0
5	Бусад орлого				0.1		
Нийт дүн		341.6	249.6	513.8	713.2	478.9	500.4

Эх сурвалж: ХЭДС-ийн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Хүснэгтээс харахад: 2016-2021 онд улсын төсвөөс хуваарилсан хөрөнгө нийт 2,040.5 сая буюу 73 хувийг, ХБИ-ийг ажиллуулаагүй ААНБ-аас төлсөн төлбөр 85.4 сая буюу 3 хувийг, санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлт 659.9 сая төгрөг буюу 23.6 хувийг, гадаад улс, ОУБ-ын зээл тусламжаар 11.6 сая төгрөг буюу 0.4 хувийг, бусад орлого 0.1 сая төгрөгийг тус тус төвлөрүүлсэн байна.

2016-2021 онд “аймгийн төсвөөс тухайн жилийн төсвийн орлогын 0.3 хувиас доошгүйгээр тооцож, хөрөнгө төвлөрүүлнэ” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй, 2016-2021 онд давхардсан

тоогоор нийт 46 ААНБ-аас 673.0 сая төгрөгийн ХБИ-ийг ажиллуулаагүй төлбөрийг төлүүлээгүй байна.

2.3.2 ХЭДС-гаас олгосон санхүүгийн дэмжлэгийг гэрээнд заасан хугацаанд эргэн төлүүлээгүйгээс 33 иргэний 43.1 сая төгрөгийн зээл төлөгдөх хугацаа хэтэрсэн байна.

ХЭДСангаас 2016-2021 онд хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээнд нийт 9 хөтөлбөр арга хэмжээг хэрэгжүүлж, 1,507.0 сая төгрөгийг зарцуулж, 7,841 иргэнийг хамруулсан байна.

2016-2021 оны ХЭДС-ийн хөтөлбөрийн зарцуулалт

Хүснэгт № 9

/сая.төг/

№	Хөтөлбөрийн нэр	Зардлын дүн, хамрагдсан хүний тоо	2016	2017	2018	2019	2020	2021	Нийт дүн
1	Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээ	хүний тоо	300	470	645	1,030	245	805	3,495
		зардлын дүн	3.6	1.1	2.7	4.3	0.7	3.7	16.2
2	Ажилд зуучлах үйлчилгээ	хүний тоо	70	297	249	492	231	378	1,717
		зардлын дүн	0.0	0.6	4.6	7.0	2.1	1.5	15.8
3	Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөр	хүний тоо	53	57	72	66	71	7	326
		зардлын дүн	9.6	7.7	6.7	6.7	6.4	0.9	38.0
4	Ажлын байрыг дэмжих хөтөлбөр	хүний тоо	442	354	272	189	219	218	1,694
		зардлын дүн	151.5	117.9	108.1	135.8	121.8	130.1	765.1
5	Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр	хүний тоо	23	1	10	86	38	35	193
		зардлын дүн	14.2	2.0	30.0	98.6	66.9	18.0	229.7
6	Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	хүний тоо	8	24	18	45	6	3	104
		зардлын дүн	34.8	24.0	28.2	56.5	20.1	14.0	177.6
7	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр	хүний тоо	55	15	24	39	24	32	189
		зардлын дүн	25.9	9.4	25.9	31.6	41.8	38.5	173.0
8	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр	хүний тоо	21	15	19	23	15	22	115
		зардлын дүн	4.2	6.4	12.6	19.9	19.7	26.4	89.3
9	Хүүхэд хамгаалагч төсөл	хүний тоо						8	8
		зардлын дүн						2.2	2.2
	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн дүн	хүний тоо	972	1233	1309	1970	849	1508	7841
		зардлын дүн	243.9	169.1	218.8	360.4	279.4	235.3	1,507.0

Эх сурвалж: ХЭДС-ийн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Говьсүмбэр аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр 2019, 2020 онд хэрэгжсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнд 2021 онд хийсэн гүйцэтгэлийн аудитаар ХЭДС-гаас 2019 онд олгосон жижиг зээлийн 6 төсөл, санхүүгийн дэмжлэг олгосон 39 төсөл, 2020 онд олгосон

жижиг зээлийн 3 төсөл, санхүүгийн дэмжлэг олгосон 40 төсөл, нийт 88 төслийн үйл ажиллагаатай танилцахаар төлөвлөснөөс 13 төсөл хэрэгжүүлэгч эзгүй байсан бөгөөд 75 төсөлтэй танилцахад төслийн үйл ажиллагаанд дараах зөрчлүүд илэрсэн. Үүнд:

2019 онд:

- ✚ Жижиг зээлээс “Хос оёдол” төсөл хэрэгжүүлэгч нийт 3 ажлын байр бий болгоно гэж гэрээ байгуулсан боловч гэрээний үүргээ биелүүлээгүй, төлөвлөсөн ажлын байрыг бий болгоогүй, зөвхөн өөртөө ажлын байр бий болгосон байна.
- ✚ Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөрөөс “Хос хүүхэлдэй”, “Хоёр эрдэнэ”, “Од кофе шоп” гэсэн нийт 3 төсөл хэрэгжүүлэгч ковид-19 цар тахал өвчний улмаас үйл ажиллагаа нь зогссон, 6 төсөл хэрэгжүүлэгч сайн дурын даатгалд хамрагдаагүй байна.
- ✚ Ажлын байрыг дэмжих хөтөлбөрөөс “Цолмон салон” ажиллуулахаар зээл авсан иргэн төслөө хэрэгжүүлэлгүй, зээлийг эргэн төлж дуусгасан, 8 төсөл хэрэгжүүлэгч сайн дурын даатгалд хамрагдаагүй байна.
- ✚ ХБИ-ийн ажлын байрыг дэмжих хөтөлбөрөөс “Блок үйлдвэрлэх” төсөл ковид-19 цар тахал өвчний улмаас үйл ажиллагаа зогссон байна.

2020 онд:

- ✚ Жижиг зээлээс “Орчин үеийн тоног төхөөрөмжтэй уламжлалт эмнэлэг”, “Боржигин голомт”, “Эрүүл хүнс амьдралын баталгаа” гэсэн 3 төсөл хэрэгжүүлэгч нийт 9 ажлын байр бий болгоно гэж гэрээ байгуулсан боловч гэрээний үүргээ биелүүлээгүй, төлөвлөсөн ажлын байрыг бий болгоогүй, сайн дурын даатгалд хамрагдаагүй байна.

Зураг №1



Зураг №2



- ✚ Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөрөөс 1 буюу “Бялуу үйлдвэрлэл” төсөл хэрэгжүүлэгч үйл ажиллагаа явуулаагүй, төсөлд заасан тоног төхөөрөмжөө аваагүй
- ✚ ХБИ-ийн ажлын байрыг дэмжих хөтөлбөрөөс “Бүжгийн сургалт” төсөл тоног төхөөрөмжийн татан авалт хийгээгүй байна.

Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд санхүүгийн дэмжлэг авсан нийт 19 иргэний бүртгэлтэй малын тоог аймгийн Статистикийн хэлтсийн ирүүлсэн статистик мэдээтэй тулган баталгаажууллаа. Үүнд:

- ✚ 2020 онд 1 төсөл хэрэгжүүлэгч 94 мал худалдан авч малжуулах хөтөлбөрт хамрагдсан боловч статистик мэдээгээр жилийн эцэст малаа тоолуулаагүй,
- ✚ Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөрөөс 2020 онд “Бялуу үйлдвэрлэл” төсөл хэрэгжүүлэхээр 10.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгосон боловч төслөө хэрэгжүүлээгүй, төслийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан, гэрээний үүргээ зөрчсөнд иргэний төслийг буцаан татаж, гэрээг цуцлах, хуульд заасан арга хэмжээг авч ажиллах талаар албан шаардлага хүргүүлсэн

Мөн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд 133 иргэний 345.6 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийн зээлийн үлдэгдэлтэй бөгөөд үүнээс 33 иргэний 43.1 сая төгрөгийн зээл төлөгдөх хугацаа хэтэрсэн байна.

Энэ нь ХЭДС-гаас олгож санхүүгийн дэмжлэгт хамрагдаж байгаа иргэд нь зээлийн гэрээнд заасны дагуу НДШ төлж, байнгын ажлын байр бий болгоогүй, үйл ажиллагааг тогтмолжуулаагүй, авсан дэмжлэгийг эргэн төлөх арга хэмжээнд чиглэсэн байна.

Иймд санхүүгийн дэмжлэгт хамрагдсан иргэдийн төслийн үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах болон, хугацаа хэтэрсэн зээлийг ХЭДС-д буцаан төлүүлж хэвийн горимд оруулах тухай зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

2.4 Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн дундаж түвшин 72 хувьтай байна.

2.4.1 МБСДС-ийн хөрөнгийг хэмнэлттэй зарцуулсан байна.

2016-2020 оны хичээлийн жилд аймгийн Политехникийн коллеж нь 3,296 суралцагчдыг мэргэжил эзэмшүүлэхэд нийт 8,063.4 сая төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 7,795.6 сая төгрөгийг зарцуулсан байна.

Аймгийн Политехникийн коллежийн 2016-2021 оны суралцагчийн тоо, батлагдсан төсөв, гүйцэтгэлийн судалгаа:

Хүснэгт №10

/сая төгрөг/

Хичээлийн жил	Хүүхдийн тоо	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Хэмнэлт
2016-2017	782	1,443.7	1,413.3	30.5
2017-2018	602	1,418.2	1,415.6	2.6
2018-2019	648	1,487.8	1,411.8	76.0
2019-2020	678	1,757.5	1,708.5	48.9
2020-2021	586	1,956.2	1,846.4	109.8
Нийт дүн	3,296	8,063.4	7,795.6	267.9

Эх сурвалж /аймгийн Политехникийн коллежийн судалгаа/

Хүснэгтээс харахад: Суралцагчдын тоо 2017-2019 онд нэмэгдсэн нь төрөөс олгодог тэтгэлгийн хэмжээ нэмэгдсэнтэй шууд холбоотой байна. 2020-2021 онд суралцагчдын тоо буурсан нь Ковид-19 цар тахал гарсан нь нөлөөлсөн байна.

2019-2020 онд Ковид-19 цар тахал гарсантай холбоотой танхимаар бүрэн хичээллээгүйгээс батлагдсан төсвийг хэмнэж ажилласан байна.

Аймгийн Политехникийн коллеж нь 2016-2020 онд 24 мэргэжлээр 1,446 төгсөгч бэлтгэн хөдөлмөрийн зах зээлд нийлүүлснээс 1,036 төгсөгч ажил хөдөлмөр эрхэлж, хөдөлмөр эрхлэлтийн түвшин дунджаар 72 хувьтай байна.

2016-2021 оны төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа

Хүснэгт №11

Хичээлийн жил	Элсэгч	Төгсөгч	Ажлын байртай	Ажилгүй	Хөдөлмөр эрхлэлтийн хувь
2016-2017	144	322	199	123	62

2017-2018	296	219	159	60	73
2018-2019	412	399	310	89	78
2019-2020	338	232	204	28	88
2020-2021	264	274	164	110	60
Нийт дүн	1,454	1,446	1,036	410	72

Эх сурвалж /аймгийн Политехникийн коллежийн судалгаа/

Хүснэгтээс харахад: 2016-2019 онд төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт нь нэмэгдсэн боловч 2020 онд өмнөх оноос 28 хувиар буурсан нь Ковид-19 цар тахал гарсан нь нөлөөлсөн байна

2.4.2 МБСДС-нд орон нутгаас зарцуулах төсөв батлаагүй байна.

Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2-т “Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих санд орон нутгийн төсвөөс олгох хөрөнгийн хэмжээг аймаг, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тухайн жилийн орон нутгийн төсөвт тусгаж батална” гэж заасан боловч 2016-2021 онд аймагт тус санд зарцуулахаар төсөвт батлаагүй байна.

2.5 “Ковид-19” цар тахлын үед хөдөлмөр эрхлэлтийн талаар төрөөс авч хэрэгжүүлсэн арга хэмжээ үр дүнтэй байна.

2.5.1 Цар тахлын үед ажлын байрыг хадгалах зорилгоор олгосон зээлийг НДХ-т бүртгэлгүй, НДШ төлөөгүй ААНБ-д олгосон байна.

Коронавируст халдвар (COVID-19)-ын цар тахлын гамшгийн эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөг бууруулж, эдийн засгийг сэргээх, зах зээлийн идэвхжилийг сайжруулах зорилгоор Монгол Улсын Засгийн газраас 2021 оны 02 дугаар сарын 17-ны өдөр “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх дунд хугацааны 10 их наядын цогц төлөвлөгөө”-г баталсан.

Энэхүү цогц төлөвлөгөөнд тусгагдсан “Ажлын байрыг дэмжих зээл”-ийг иргэнд 50.0 сая хүртэл, НӨАТ төлөгч аж ахуйн нэгжид 500 сая хүртэл төгрөгийн зээлийг жилийн 3 хувийн хүүтэй 3 жилийн хугацаатайгаар олгосон байна.

Говьсүмбэр аймагт 2021 онд “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх дунд хугацааны 10 их наядын цогц төлөвлөгөө”-ний хүрээнд ХААН, ХАС, Төрийн банкнаас 456 иргэн, 44 ААНБ-д нийт 17,292.6 сая төгрөгийн зээлийг олгосон байна. Үүнээс ажлын байрыг дэмжих чиглэлээр 129 иргэнд 4,372.4 сая, 44 ААНБ-д 6,703.5 сая төгрөгийн зээлийг олгосон бол малчдыг дэмжих чиглэлээр 327 малчинд 6,216.7 сая төгрөгийн зээлийг олгожээ.

Ажлын байрыг дэмжих болон малчдыг дэмжих зээлийн судалгаа

Хүснэгт №12

/сая төгрөг/

Банкны нэр	Ажлын байр дэмжих зээл				Малчдыг дэмжих зээл	
	Иргэн		ААНБ			
	Тоо	Зээл	Тоо	Зээл	Тоо	Зээл
Хас банк	10	350.2	8	1,550.5	0	0.0
Хаан банк	21	748.7	19	3,995.0	236	4,482.6
Төрийн банк	98	3,273.5	17	1,158.0	91	1,734.1
Нийт дүн	129	4,372.4	44	6,703.5	327	6,216.7

Эх сурвалж /Банкны зээл олгосон судалгаа /

Зээлд хамрагдсан ААНБ-ыг орон нутагт бүртгэлтэй эсэх, татвар, НДШ төлдөг эсэх, үйл ажиллагаа явуулдаг эсэхийг тодруулахаар аймгийн Татварын хэлтэс болон Нийгмийн даатгалын хэлтсээс лавлагаа авахад дараах зөрчил илэрлээ.

- Орон нутагт татвар, НДШ төлөгч байгууллагаар бүртгэгдээгүй “Харвайн толгой ХХК”-нд Хас банкнаас ажлын байр дэмжих чиглэлээр 100.0 сая төгрөгийн зээлийг олгосон нь орон нутагт бодит ажлын байр нэмэгдэх боломжгүй, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого хэрэгжээгүй, дэмжлэг бодит эзнээ олоогүй
- Төрийн банкнаас “Их зэст хөгжил” ХХК 15.0 сая, “Энгүүн сүмбэр” ХХК-д 70.0 сая, “Их богд эрдэнэ транс” ХХК-д 80.0 сая, нийт 165.0 сая төгрөгийн зээл олгосон боловч аймгийн НДХ-т бүртгэлгүй, НДШ төлөөгүй, Төрийн банкнаас “Болор мөнгөн мөчир” ХХК 80.0 сая, Хаан банкнаас “Оцол гурван сансар” ХХК 50.0 сая, нийт 130.0 сая төгрөгийн зээл авсан боловч 2021 онд үйл ажиллагаа явуулаагүй нэрээр НДШ төлөөгүй байна.

2.5.2 Цар тахлын үед ажилтныг дэмжих чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ үр дүнтэй байна.

Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2021 оны 2 дугаар сарын 9-ний өдрийн 1 дүгээрийн тогтоолын 2 дугаар хавсралтаар “Цар тахлын үед аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөр”-ийг баталсан байна.

Тус хөтөлбөрийн зорилго нь Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлын үед үйлдвэрлэл, үйлчилгээ, мал аж ахуй эрхлэгчдэд үйл ажиллагаагаа сэргээхэд чиглэсэн барьцаагүй, хүүгүй, эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэг болон санхүүгийн бус дэмжлэг үзүүлж, ажлын байр бий болгох, хадгалах, хамгаалах санаачилгыг дэмжих, иргэдийн орлогыг нэмэгдүүлэхэд чиглэсэн байна.

Тус хөтөлбөрт хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлийн дараах 5 хөтөлбөр, арга хэмжээнд 267.7 сая төгрөгийн төсөв батлагдаж, 226.8 сая төгрөг зарцуулагдаж, 310 байнгын ажлын байр бий болсон гэж бүртгэсэн байна.

Хүснэгт 13. Хөтөлбөрийн төлөвлөгөө, гүйцэтгэл

/сая төгрөг/

№	Төсөл, хөтөлбөрийн нэр	2021 он				Ажлын байр	
		Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Зөрүү	Хамрагдсан хүний тоо	байнгын	Түр
1	Ажлын байрыг дэмжих	136.7	130.1	6.6	218	75	143
2	Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих	18.4	18.0	0.4	35	35	
3	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих	70.2	38.5	31.7	32	32	
4	Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	16.1	14.0	2.1	3	3	
5	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх	26.4	26.4	0.0	22	22	
	Нийт дүн	267.7	226.9	40.8	310	167	143

Эх сурвалж: ХЭДС-ийн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Нийт санхүүжилтийн 74 хувийг ажлын байрыг дэмжих, 19 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих, 7 хувийг малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт тус тус зарцуулсан хэдий ч хэрэгжүүлсэн хөтөлбөрүүдийн үр дүнд дэмжигдсэн нийт ажлын байрны 46.1 хувийг түр ажлын байр эзэлж байгаа нь тогтвортой, үр нөлөө бүхий арга хэмжээ болж чадаагүй болохыг харуулж байна.

Хүснэгт №14.

Цар тахлын улмаас хөдөлмөр эрхлэлтийн салбарт гарсан өөрчлөлтүүд

Он	Үзүүлэлт	ХБИ дэмжих	ЗХЭД, гарааны бизнесийг дэмжих	Малчдын хөдөлмөр эрхлэлт	Ажлын байрыг дэмжих	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ	Нийт дүн
2019	Хүний тоо	39	86	45	189	23	382
	Зарцуулсан хөрөнгө /сая төгрөг/	31.6	98.6	56.5	135.8	19.9	342.4
	Бий болсон байнгын ажлын байр	39	86	45	189	23	382
2020	Хүний тоо	24	38	6	219	15	302
	Зарцуулсан хөрөнгө /сая төгрөг/	41.8	66.9	20.1	121.8	19.7	270.3
	Бий болсон байнгын ажлын байр	24	38	6	219	15	302
2021	Хүний тоо	32	35	3	218	22	310
	Зарцуулсан хөрөнгө /сая төгрөг/	32.5	18.0	14.0	128.7	26.4	219.6
	Бий болсон байнгын ажлын байр	32	35	3	218	22	310

Эх сурвалж: ХХҮГ-ын тайлан, мэдээ

Хүснэгтээс харахад цар тахлын үед буюу 2020, 2021 оныг 2019 онтой харьцуулахад хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн санхүүжилт 21-36 хувиар, байнгын ажлын байр 18.8-20.9 хувиар буурсан буюу цар тахал нь хөдөлмөр эрхлэлтийн салбарт сөргөөр нөлөөлсөн байна.

2021 онд Залуучуудын хөгжил, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, хувь хүний хөгжлийн цогц сургалтын хөтөлбөр боловсруулан, залуучуудыг хамруулж хөдөлмөрт бэлтгэх, ажлын байраар хангахад дэмжлэг үзүүлэх зорилт, 2021 оны 58 дугаар тогтоолоор батлагдсан “Залуучуудын хөдөлмөрт бэлтгэх төсөл”-ийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний дагуу “Оролцоо төслийг ХНХЯ, ХХҮЕГ хамтран улсын хэмжээнд нэгдсэн байдлаар зохион байгуулсан байна

Дээрх арга хэмжээг байгууллагын болон орон нутгийн цахим мэдээллийн хэрэгсэл, явуулын үйлчилгээгээр сурталчилж, 86 залуучуудыг бүртгэж, үүнээс: 34 залуучуудыг хувь хөгжил, АМЧБ олгох, зөвлөгөө өгөх 14 хоногийн вакумжуулсан сургалтад хамруулж, сургалтын тэтгэлэг 34, дадлагын тэтгэлэг 23 залуучуудад олгож, 11 залуучуудыг ажилд зуучилсан байна.

Мөн цар тахлын үед ажлын байрыг хадгалах зорилгоор ЗГ-аас авч хэрэгжүүлсэн арга хэмжээний хүрээнд Говьсүмбэр аймагт 137 ААНБ-д 2020 онд 1,058.7 сая, 645 иргэнд 231.6 сая, 2021 онд 215.4 сая, 500 иргэнд 55.1 сая, нийт 1,560.8 сая төгрөгийн НДШ-ийн хөнгөлөлт чөлөөлөлтийг эдлүүлж, ажилгүйдлийн даатгалын сангаас 30 ААНБ-д 105.4 сая төгрөгийн дэмжлэгийг олгосон байна.

2.5.3 Цар тахлын үеийн сөрөг нөлөөллөөс зорилтот бүлгийн хөдөлмөр эрхлэлт, ажлын байрыг хамгаалахаар хэрэгжүүлж буй арга хэмжээ үр дүнтэй байна

ХЭДС-ийн "Цар тахлын үед аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөрийн хүрээнд малжуулах төсөлд 3 өрхөд 14.0 сая төгрөг, ажлын байрыг дэмжих хөтөлбөрт 16 иргэнд 80.0 сая төгрөг, залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт 1 бүлэгт 10.0 сая, ХБИ-ний хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд 10 иргэнд 36.0 сая, ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд 8 иргэнд 18.0 сая, нийт 158.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгож, ажил олгогчийн урамшуулалд 2 ААН-д 10.0 сая төгрөг, 3 иргэнд 1.3 сая төгрөгийн түрээсийн хөнгөлөлт тус тус олгосон байна.

ХЭДС-ийн эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэгт хамрагдсан иргэдээс гэрээний үүргээ бүрэн хангасан 40 иргэний ХЭДС-д хуваарийн дагуу төлөх 37.7 сая төгрөгийн төлбөрийг 2021 оны 01 дүгээр сарын 01-нээс 2021 оны 07 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл иргэний хүсэлтийг харгалзан хойшлуулж, дэмжлэг үзүүлсэн байна.

2.5.4 Цар тахлын улмаас аймгийн хөдөлмөр эрхлэлт буурч, ажилгүй иргэд 18.3 хувиар өссөн байна.

2021 онд өмнөх оноос хөдөлмөр насны хүн амын тоо 128 хүнээр буюу 1.2 хувиар буурч, харин ажиллах хүчнээс гадуурх хүн ам 187 хүнээр буюу 5.2 хувиар өссөн байна.

Цар тахлын үеийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа

Хүснэгт №15

Үзүүлэлт	2020 он	2021 он	Зөрүү	Хувиар
Хөдөлмөрийн насны хүн ам	11057	10929	-128	-1.2
Үүнээс: Ажиллах хүч	7495	7180	-315	-4.2
Ажиллагчид	6751	6300	-451	-6.7
Ажилгүй хүн	744	880	136	18.3
Ажиллах хүчнээс гадуурх хүн ам	3562	3749	187	5.2

Эх сурвалж / www.1212.mn/

Хүснэгтээс харахад: 2021 онд ажиллагчид өмнөх оноос 451 буюу 6.7 хувиар буурсан бол ажилгүй иргэд 136 буюу 18.3 хувиар өссөн байна.

2021 онд аймгийн хөдөлмөр эрхлэлтийн түвшин 61 хувь байсан бол 2021 онд 57.6 хувь болж 3.4 хувиар буурсан байна.

Энэ нь ажиллах хүчин буурч түүнээс шалтгаалан ажиллагчид буурсантай шууд холбоотой байна. мөн 2020 онд ковид-19 цар тахал гарсантай холбоотой, ажиллагчид буурснаар ажилгүй хүний тоо, ажиллах хүчнээс гадуурх хүн амын тоо тус тус нэмэгдсэн байна.

Гүйцэтгэлийн аудитаар нийт 43.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, 5 зөвлөмж өгч, УАГ-т уламжлах 2 санал хүргүүлэв.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

Бүлэг 1: Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр орон нутгийн онцлогт тохирсон бодлогын баримт бичиг боловсруулаагүй, төрийн байгууллагууд ажлын уялдаа холбоо, хамтын ажиллагааг сайжруулах шаардлагатай байна.

- 1.1 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр урт болон дунд хугацаанд хэрэгжүүлэхээр баталсан бодлогын баримт бичгүүдийн хоорондын уялдаа бүрэн хангагдахгүй байна.
- 1.2 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих ажлын байрыг нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг үндэслэлтэй төлөвлөж чадаагүй байна.
- 1.3 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиг үүрэг бүхий төрийн байгууллагуудын ажлын уялдаа холбоо, хамтын ажиллагааг сайжруулах шаардлагатай байна.

Бүлэг 2. ХЭДС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн хангалтгүй, ажилгүйдэл буураагүй байна.

- 2.1 Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээнд хамаарах үйл ажиллагааны үр дүнг үнэлж, тооцоогүй байна.
- 2.2 Засгийн газраас хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажилгүйдлийг бууруулах, ажлын байр нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээ үр нөлөөгүй байна
- 2.3 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг хуулийн дагуу бүрэн төвлөрүүлээгүй байна.
- 2.4 Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн дундаж түвшин 72 хувьтай байна.
- 2.5 "Ковид-19" цар тахлын үед хөдөлмөр эрхлэлтийн талаар төрөөс авч хэрэгжүүлсэн арга хэмжээ үр дүнтэй байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын нотлох баримт, аудитын дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан байгууллага, албан тушаалтанд зөвлөж байна.

Аймгийн Засаг дарга бөгөөд ХЭАСЗ-ийн даргад:

1. Бодлогын хэрэгжилтийг хангахад ажлын уялдаа холбоогоо сайжруулж, орон нутгийн байгууллагуудтай хамтран ажиллах
2. Салбар зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, зөвлөлийн гишүүдийг чадавхижуулах, үүрэг оролцоог нэмэгдүүлэх

Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газарт:

1. Санхүүгийн дэмжлэгт хамрагдсан иргэдийн төслийн үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулж, бодит ажлын байрыг бий болгох
2. Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтэд үндэслэн мэргэжилтэй ажилтныг бэлтгэж, ажил олгогч ажилтан хоёрын эрэлтэд нийцсэн арга хэмжээг зохион байгуулж үр дүнг тооцох
3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр төрийн захиргааны байгууллагуудтай харилцан уялдаатай хамтран ажиллах

ДЭЭД ШАТНЫ БАЙГУУЛЛАГАД ХҮРГҮҮЛЭХ САНАЛ

Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн”-д хийсэн аудитын үр дүнд бодлогын түвшинд нэгтгэн шийдвэрлэх дараах асуудлууд байна. Үүнд:

1. ХБИ орлогыг төвлөрүүлэхэд ХХҮГ-ын хууль эрх зүйн чадамж нь байдаггүй, албан тоот, нэхэмжлэх бичиж өгөхөөс хэтэрдэггүй тул ХБИ ажиллуулаагүйн төлбөрийн орлогыг бүрдүүлэх хууль эрх зүйн орчныг сайжруулах
2. Зөвлөлийн дүрэмд зөвлөлийн удирдлага зохион байгуулалтыг тодорхой зааж, зөвлөлийн нарийн бичгийн даргаар ХХҮГ-ын хөдөлмөр, эрхлэлтийн хэлтсийн дарга байхаар заасан нь зөвлөлийн үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэхэд тохиромжтой бус байна. Иймд зөвлөл нь эрх, үүргийн хүрээнд орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийн бодлого үйл ажиллагааг удирдан зохицуулах, хяналт тавих тул АЗДТГ-ын нийгмийн бодлогын асуудал хариуцсан мэргэжилтэн нарийн бичгийн даргыг хийх нь оновчтой, бодлогын чиг үүрэг үр дүнтэй хэрэгжинэ гэж үзэж байна.

ШАЛГАГДАГЧ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ



ГОВЬСҮМБЭР АЙМАГ ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗАР

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг,
Утас/Факс: (976) 7054 3518,
E-mail: govsumber.hudulmur.halamj@gmail.com

2022-05-10 № 01/209
танай -ны № -т

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

А/а Н. Батсайхан
Тайлбартай
Төрийн аудитын газар
түрэмг бичиг
2/10

Тайлбар хүргүүлэх тухай

“Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх, чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн маягтад бүртгэгдсэн 33 иргэний 43.1 сая төгрөгийн албан шаардлагыг хүлээн зөвшөөрөх боломжгүй байна. Учир нь албан шаардлагад туссан дүн дотор:

1. Т.Уянга /6.82 сая төгрөг/- шүүхийн шийдвэр гарсан төлөгдөж байгаа.
2. С.Алтантуяа /4.7 сая төгрөг/ хаяг тодорхойгүй, гадаадад гараад олдохгүй байсныг судалж Дорноговь аймгийн Айраг суманд байгаа талаар 2022 оны 4 сард мэдээлэл авч эрэн сурвалжлуулахаар аймгийн Шүүхэд хандсан.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын Эрх зүй, хамтын ажиллагааны хэлтсээс гэрээний хугацаа дуусаагүй үед шүүхэд хандсан нэхэмжлэлийн шаардлага хангагдахгүй байх магадлал өндөр гэж зөвлөсний дагуу 31 иргэний 31,4 сая төгрөг нь гэрээний хугацаа дуусаагүй байсан учир Шүүхэд хандах боломжгүй байсан болно.

Мөн 2021 онд ковидын улмаас эргэн төлөлт удааширсан нэр бүхий харилцагчдад удаа дараа албан мэдэгдэл хүргүүлж ажилласан.

ДАРГА Х.БУЯНБАЯР



D:\бичиг хэрэг\А4 тоот 1 .docx

42 0300051

ШАЛГАГДАГЧ БАЙГУУЛЛАГЫН САНАЛД ӨГСӨН ТАЙЛБАР

Аймгийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын тайлангийн төсөлд ирүүлсэн саналтай танилцаад 43.1 сая төгрөгийн албан шаардлагыг зөвлөмж өгөхөөр тайланд өөрчлөлт оруулав.

ХАВСРАЛТ

Хавсралт 1

Хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүй төлбөрийн 2016-2021 оны судалгаа

Он	25-аас дээш ажилтантай ААНБ-ын тоо	ХБИ ажиллуулсан байгууллагын тоо	Төлбөр төлөх байгууллагын тоо	Төлбөрөөс чөлөөлөгдсөн байгууллагын тоо	Төлбөр төлөх ААНБ-ын тоо	Төлбөр төлсөн ААНБ-ын тоо	Төлбөр төлөөгүй ААНБ-ын тоо	Төлөх төлбөр	Төлсөн төлбөр	Төлөгдөөгүй төлбөр
2021	40	27	13	1	12	1	11	348.5	1.1	347.3
2020	37	20	17	0	17	3	14	118.3	17.4	101.0
2019	38	19	19	0	19	9	10	207.7	46.1	161.6
2018	36	19	17	6	11	3	8	31.1	1.1	30.0
2017	35	23	12	0	12	10	2	44.5	11.3	33.2
2016	31	21	10	0	10	9	1	8.2	8.4	-0.1
	217	129	88	7	81	35	46	758.3	85.3	673.0